



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Батцэнгэл сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2023/06-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Архангай аймаг 2023 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: <a href="mailto:Baigalmaat@audit.gov.mn">Baigalmaat@audit.gov.mn</a> Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: <a href="mailto:Nerguibaatard@audit.gov.mn">Nerguibaatard@audit.gov.mn</a> Аудитор Н.Энхчимэг Утас: 7033-3019 Цахим хаяг: <a href="mailto:Enkhchimegn@audit.gov.mn">Enkhchimegn@audit.gov.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

Б А Т Ц Э Н Г Э Л С У М Ы Н З А С А Г Д А Р Г А  
Ц. З О Р И Г Т Х У У Т А Н А А

2023-03-22 № 134

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Батцэнгэл сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдэн, мөрдөгдсөнтэй холбоотой Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, газрын төлбөр, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулсан хувь хүний орлогын албан татварын орлогууд сумын төсвийн орлогод нэмэгдэж төвлөрсөн.

#### Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 6 үндсэн зорилтын хүрээнд 128 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 79.3 хувьтай үнэлсэн байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,028,085.0	673,128.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	410,982.1	282,844.8
33	АВЛАГА	295,918.0	340,101.2
35	БАРАА МАТЕРИАЛ	304,886.5	50,182.6
36	НӨӨЦИЙН БАРАА	16,298.4	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,436,788.9	2,425,626.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,436,788.9	2,425,626.3
39200	Биет хөрөнгө	5,340,917.6	2,413,155.0
39300	Биет бус хөрөнгө	95,871.3	12,471.3
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,464,873.9	3,098,754.9
4	НИИТ ӨР ТӨЛБӨР	9,731.6	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,731.6	0.0
41300	Өглөг	9,731.6	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,455,142.3	3,098,754.9
51	Засгийн газрын хувь оролцоо	6,455,142.3	3,098,754.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,975,885.8	418,921.1
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0.0	418,921.1
51200	Хуримтлагдсан үр дүн	3,403,395.1	2,651,874.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,075,861.4	27,959.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,464,873.9	3,098,754.9

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,405,673.1	1,388,039.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	280,375.7	467,357.6
110	Орлогын албан татвар	110,610.9	271,608.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	110,610.9	271,602.5
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	6.3
113	Хөрөнгийн албан татвар	66,683.7	92,360.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	103,081.1	103,388.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	493,867.5	377,570.9
120	Нийтлэг татварын бус орлого	490,314.5	377,570.9
122	Тусламжийн орлого	3,553.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,631,430.0	543,110.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,176,922.8	916,677.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,176,922.8	916,677.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,094,349.9	856,585.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,820,096.1	400,992.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	246,939.4	49,873.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,388.6	118,662.2
2104	Хангамж, бараа материалын зардал	87,846.6	59,163.7
2105	Нормативт зардал	415,982.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,234.8	17,712.0
2107	Томилолт, зочны зардал	1,846.5	2,628.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,714.8	24,629.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	362,301.1	182,925.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,572.9	60,092.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	228,750.3	471,361.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	57,901.6	3,776,399.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИИТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	170,848.8	-3,305,037.1

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,594,846.4	1,154,827.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	280,375.7	467,357.6
110	Орлогын албан татвар	110,610.9	271,608.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	110,610.9	271,602.5
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	6.3
113	Хөрөнгийн албан татвар	66,683.7	92,360.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	103,081.1	103,388.5

**Архангай аймгийн Батцэнгэл сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,405.5	15,954.4
1181	Газрын төлбөр	71,917.9	6,242.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	21,757.6	81,191.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	149,281.9	144,359.4
120	Нийтлэг татварын бус орлого	149,281.9	144,359.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,165,188.8	543,110.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,166,405.3	740,957.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,166,405.3	740,957.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,488,243.2	680,965.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,820,096.1	400,937.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	237,207.8	49,873.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,849.4	114,268.7
2104	Хангамж, бараа материалын зардал	70,669.7	43,600.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,071.8	17,870.5
2107	Томилолт, зочны зардал	1,845.2	2,628.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,611.3	27,987.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,118.9	23,800.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	678,162.2	59,991.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	428,441.0	413,870.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	113,771.9	307,008.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	113,771.9	307,008.1
2200	Дотоод эх үүсвэрээр	113,771.9	307,008.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-113,771.9	-307,008.1
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-235,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	235,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	314,669.2	-128,137.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	96,313.0	410,982.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	410,982.1	282,844.8

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,274,347.7	6,274,347.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	9,945.8	9,945.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,284,293.5	6,284,293.5
4	Тайлант үеийн үр дүн	170,848.8	170,848.8
5	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,455,142.3	6,455,142.3
6	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,455,142.3	6,455,142.3
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-51,350.3	-51,350.3
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,403,792.0	6,403,792.0
9	Тайлант үеийн үр дүн	-3,305,037.1	-3,305,037.1
10	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,098,754.9	3,098,754.9

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар залруулагдаагүй нийт **169,114.6** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч зөрчил арилгуулах 3 албан шаардлага хүргүүлээ.

#### 3.2 Албан шаардлага

3.2.1 Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тулган шалгахад 19 зээлдэгчтэй холбоотой 55.3 сая төгрөгийн төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, мөн 10 дугаар зүйлийн 10.1-т “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина.”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу төвлөрүүлэхэд онцгой анхаарч, зээлийг барагдуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.*

3.2.2 Сум хөгжүүлэх санд 2012 оны багийн хөгжүүлэх сангаас 6 багийн засаг даргад 36.7 сая төгрөгийн зээл олгосон бөгөөд одоог хүртэл зээлийг /сум хөгжүүлэх сан/, хоршоо хөгжүүлэх санд буцаан төвлөрүүлээгүй байна. Энэ Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоол баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах хяналт тавих журам, мөн 2016 оны 153 дугаар тогтоол, одоо мөрдөгдөж байгаа Засгийн газрын 2022 оны 81 дүгээр тогтоолоор баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу төвлөрүүлэхэд онцгой анхаарч, зээлийг барагдуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.*

3.2.3 Төсвийн орлогын гүйцэтгэл тайлант жилд орлогын төлөвлөгөөний дийлэнх хувь болох малын хөлийн татвар 77,011.5 мянган төгрөгөөр тасарсан нь төсвийн тухай хуулийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна

*Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг мөрдөж, орлогын төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслэн хийж, нэр төрлөөр жигд ханган биелүүлэх албан шаардлагыг хүргүүлээ.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

#### 4 АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Батцэнгэл сумын ТТЗ	4	169114.6			4	169114.6							